



Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: **ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН ЭДИЙН
ЗАСАГ БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ**

Хөтөлбөрийн нэр: **“МЕНЕЖМЕНТ”**

Индекс: **D041302**

Шинжээчийн баг:

Ахлагч: Л.Наранчимэг

Гишүүд: М.Банзрагч

Ч.Төрбадрах

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний зөвлөл
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам гэх мэт
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их сургууль

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ХААИС-ЭДИЙН ЗАСАГ БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ MONGOLIAN STATE UNIVERSITY OF LIFE SCIENCES	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Менежмент /Management/	
Индекс	D041302	
Шинжээчид	Ахлагч: Л.Наранчимэг Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн профессор, доктор Гишүүд: М.Банзрагч Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн дэд захирал, доктор Ч.Төрбадрах Мандах их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал, доктор	
Зохицуулагч	Ц.Цацрал Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2021.11.25	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон. №А/140
	2021.11.30	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан.
	2021.12.08	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2021.12.11.12	Сургууль дээр илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийсэн.
	2021.12.19	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.
	2021.12.21	Шинжээчийн багийн тайланг сургуульд илгээн санал авсан.
		Шинжээчийн баг тайланг эцэслэн боловсруулж, ажлын албанд хүлээлгэн өгсөн.

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Зорилго: Олон улсын жишигт нийцсэн, өрсөлдөх чадвар бүхий бизнесийн менежер бэлтгэхэд оршино.

Хөтөлбөрийн хүрэх үр дүн PLOs (Program Learning Outcomes)

1. Олон улсын жишигт нийцсэн үндэсний хөтөлбөрийн магадлан итгэмжлэлээр хөтөлбөрөө үнэлүүлнэ. ОУ-ын ACBSP -ын магадлан итгэмжлэлд 2 дахь удаагаа хөтөлбөрөө үнэлүүлнэ.
2. БШУЯ болон их сургуулийн удирдлагаас гаргаж буй хууль, дүрэм журмыг биелүүлж, ёс зүйн өндөр түвшинд шүүмжлэлтэй хандаж зөв үнэлэмж өгөх харилцааны орчинг бүрдүүлнэ. Элсэгчийн тоо, чанарыг нэмгдүүлнэ. Хөтөлбөрийг хөгжүүлэх нэгдсэг төлөвлөгөөг боловсруулж төгсөгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх, үнэлэх тогтолцоог бий болгоно.
3. Сургалтыг үр дүнд суурилсан арга технологиор үнэлэх үнэлгээний системийг улам төгөлдөржүүлнэ. Хичээлээр олгох мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэхдээ тухайн хичээлийн онцлогийг харгалзан тогтоох боломжийг олгоно. Цахим сургалтын орчныг улам сайжруулж багш нарыг компьютер, техник хэрэгслээр хангах асуудлыг багшийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ
4. Менежментийн улсын олимпиадыг цахим олимпиад болгож олон улсын түвшинд гаргах эхлэлийг тавина. Олон улсын түвшинд хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн ЭШ-ний сэтгүүлд 2-оос доошгүй өгүүлэл хэвлүүлнэ. Хувийн хэвшил болон мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагаагаа өргөжүүлж ажиллана.

Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives)

1. Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагын шаардлагад нийцсэн хөтөлбөрөөр даяаршсан нийгмийн эрэлт хэрэгцээг хангасан мэргэжилтэн бэлтгэх
2. Хууль дүрмийг чандлан мөрдөх, нийгмийн хариуцлагатай байх, ёс зүйн зөв үнэлэмж өгөх чадвар эзэмшүүлэх
3. Асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй хандах, бусадтай хамтран ажиллах, шинийг эрэлхийлэгч, зөв хандлагатай харилцааны ур чадвар эзэмшүүлэх
4. ХАА-н болон эдийн засгийн бусад салбарын бизнесийн , бизнесийн бус байгууллагуудын үйлдвэрлэл, үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах, манлайлах, хянах, шинжилгээ хийх арга зүй эзэмшүүлэх

Хөтөлбөрийн төгсөгчийн загвар

Мэргэжлийн ур чадвар:

Хувь хүний мэргэжлийн ур чадвар, дадал

Бизнесийн суурь мэдлэгийг эзэмших, ашиглах ур чадвар дадал

ХАА-н үндсэн асуудлуудыг тодорхойлох, эзэмших, ашиглах ур чадвар

Хувь хүний ур чадвар:

Мэдээлэлд шинжлэх ухаанчаар хандах, задлан шинжлэх нэгтгэн дүгнэх чадвар

Багаар болон ганцаарчилан ажиллах чадвар

Харилцааны ур чадвар

Мэргэжлийн мэдлэг:

Бизнесийн үйл ажиллагааг төлөвлөх, шинжилгээ хийх

Бизнесийн үйл ажиллагааг зохион байгуулах, хянах

Бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ хийх

Бизнесийн санхүүгийн нөөцийг оновчтой удирдах, үйл ажиллагаанд шинжилгээ хийх, хяналт тавих

Бизнесийн үйл ажиллагааны асуудлуудыг ойлгох, шинжлэх

Хандлага:

Асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй хандах, эрх зүйт ёсыг дээдлэх, хууль дүрэм журмыг мөрдөх, ёс суртахууны хэм хэмжээг чандлан сахих хандлага

Бусадтай хамтран ажиллах, шинийг эрэлхийлэгч, бүтээлч байх хандлага

Сургалтын төлөвлөгөөний бүтэц

Хичээлийн нэр	Заавал судлах /кц/	Сонгон судлах /кц/	Нийт кредит цаг
1. Боловсролын суурь хичээл	34		34
2. Мэргэжлийн суурь хичээл	30	3	33
3. Мэргэшүүлэх хичээл	48	12	60
Дүн	112	15	127

Хөтөлбөрийн хичээлийн онол, практикийн харьцуулалт

Сургалтын агуулга	Судлах байдал	Хичээлийн хөтөлбөр дэхь хичээлийн хэлбэр	Кредит цаг
1. Боловсролын суурь хичээл	Заавал	Лекцийн кц	17
		Семинарын кц	17
2. Мэргэжлийн суурь хичээл	Заавал	Лекцийн кц	15
		Семинарын кц	15
	Сонгон	Лекцийн кц	1,5
		Семинарын кц	1,5

3. Мэргэшүүлэх хичээл	Заавал	Лекцийн кц	24
		Семинарын кц	24
	Сонгон	Лекцийн кц	6
		Семинарын кц	6
Нийт кредит цаг	Заавал	Лекцийн кц	56
		Семинарын кц	56
	Сонгон	Лекцийн кц	7,5
		Семинарын кц	7,5

Хөтөлбөрийн онцлог:

Тус хөтөлбөрөөр 1991 оноос элсэлт авч нийт 1573 менежер мэргэжилтэн бэлтгэсэн бөгөөд төгсөгчид нь бизнесийн болон бизнесийн бус салбарт захирал, менежер, гүйцэтгэх захирал, их дээд сургуулийн багш, тэнхмийн эрхлэгч зэрэг албан тушаалуудад ажиллаж байна. Тус хөтөлбөр нь 14 багш ажилтантай. Багш нарын 30,7 хувь нь докторын зэрэгтэй. Менежмент хөтөлбөр нь БМИҮЗ-өөр 2009 онд, олон улсын магадлан итгэмжлэийн (ACBSP) байгууллагаар 2014 онд тус тус магадлан итгэмжлүүлсэн.

Менежмент хөтөлбөр нь гадаад, дотоодын олон байгууллага, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажилладаг ба ХАА-н салбарын үйлдвэрлэл, үйл ажиллагааны менежмент, хөдөөгийн хөгжил, байгаль орчин, жижиг дунд үйлдвэрлэл, нийгэм эдийн засгийн судалгаа хийдэг. Монгол улсын хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвар бүхий хөтөлбөр юм.

Ш. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Үндэсний статистикийн хорооны тоо мэдээлэл болон дэлхийн эдийн засгийн форум-2020, АНУ-ын хөдөлмөрийн статистикийн товчооны тоо мэдээллийг ашиглан мэргэжлийн ирээдүйн төлөв байдлыг тодорхойлсон судалгаа
- Хөтөлбөрийн PEST шинжилгээг хийсэн.
- Дотоодын МУИС, ШУТИС, гадаадын Голландын Вагенингений ИС, Унгарын Дебрецийн ИС-иудын менежмент хөтөлбөртэй харьцуулсан судалгааг хийсэн.
- 2015 оноос хойш хөтөлбөрт 2 удаагийн өөрчлөлт орсон

Анхаарах асуудал:

- Тухайн хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, хөгжлийн чиг хандлагын талаарх судалгааг тогтмолжуулах

Зөвлөмж:

- Гадаад, дотоодын ИДС-ын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа хийж үр дүнг нэгтгэж, дүгнэх улмаар хөтөлбөрийн сайжруулалт хийх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн 2015-2020 онд хүрсэн үр дүнг тодорхойлж, 2025 онд хүрэх үр дүнг тодорхойлсон байна.
- ХААИС, ЭЗБС, Менежментийн хөтөлбөрийн эрхэм зорилго, зорилтуулын уялдааг гаргасан.
- Хөтөлбөрт сайжруулалт хийхдээ оролцогч талуудын саналыг үндэслэн сайжруулалт хийдэг.

Онцлог зүйл/Туршлага:

- Бизнесийн менежмент мэргэжлээр төгсөгчийн загварыг боловсруулсан

Анхаарах асуудал:

- ХААИС-ийн 2019-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулагдан мөрдөж байгаа боловч Эдийн засаг бизнесийн сургуулийн 2011-2020 оны стратеги төлөвлөгөөнүүд мөрдөгдөж байгаа нь хоорондоо уялдаа муутай байна.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтууд нь хэт дэлгэрэнгүй, тэнхимийн зорилго тодорхой бус
- Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тодорхойлохдоо ажил олгогч, төгсөгч, суралцагч гэх мэт оролцогч талуудын саналыг төдийлөн тусгаагүй. Тайланд энэ талаар судалгаа авдаг гэж бичсэн боловч хөтөлбөрийн зорилго, зорилтуудын талаарх судалгаа дутмаг

Зөвлөмж:

- Салбар сургуулийн болон тэнхимийн стратеги төлөвлөгөөг ХААИС-ийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулж боловсруулж хэрэгжүүлэх.
- Тэнхимийн болон хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг (PLO) сайжруулах, боловсруулах. Оролцогч талуудын саналыг бодитоор тусгах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- 2014 оноос одоог хүртэл “ Менежмент” /D 041302/ мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж байна.
- Бизнесийн менежментийн хөтөлбөрийн хороо оролцогч талуудын оролцоотойгоор ажилладаг.
- Захирлын 2017 оны А/183 тоот тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөө /нийт 127 багц цэг/ мөрдөгдөж байна. Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлсон.
- Хичээлүүдээр эзэмших мэдлэг, ур чадвар, дадал хөтөлбөрийн үр дүн хоорондын нийцлийг тодорхойлсон.
- Хичээлийн стандарт хөтөлбөрийг мөрдлөг болгодог.Хөтөлбөрийн үнэлгээг үр дүнгийн үнэлгээ, хичээлийн үр дүнгийн үнэлгээ гэсэн 2 хэсэгт хуваан үздэг.\

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөөг 2017 оноос хойш шинэчлээгүй, сонгон судлах хичээлийн тоо, цаг бага байна. Тухайлбал: Мэргэшүүлэх чиглэлийн 2 хичээлийн 6 багц цагаас, 1 хичээл буюу 3 багц цагийг сонгохоор оруулсан нь сонголт мөн гэхэд эргэлзээтэй байна.
- Хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн уялдааг сайжруулах
- Хичээлийн хөтөлбөрүүдэд 2017 оноос хойш өөрчлөлт хийгдээгүй

Зөвлөмж:

- Харьцуулсан судалгаа, оролцогч талуудын санал асуулгын үндсэн дээр сургалтын төлөвлөгөөг сайжруулах, шинэчлэх
- Хичээлийн хөтөлбөрүүдэд өөрчлөлт орсон тухай бүр тэмдэглэгээ хийж, баталгаажуулах

Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- “Менежмент” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- БСШУЯ-ны сайдын тушаал 2011, 2014
- ХААИС-ийн захирлын 2014, 2015, 2016 болон 2017 оны тушаал
- Батлагдсан сургалтын төлөвлөгөө 2011, 2015, 2017
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- Тэнхимийн хурлын тэмдэглэл 2015-2020
- Хөтөлбөрийн хичээлийн стандарт төлөвлөгөө
- ХААИС-ийн оюутны гарын авлага
- ХААИС-ийн багшийн гарын авлага
- Оюутны болон төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгаа

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтуудтай мэдлэг ур чадвар хэрхэн уялдах уялдааг харуулсан.
- Хөтөлбөрийн шинэчлэлийг оролцогч талуудын оролцоотой тогтмол сайжруулдаг.
- Суралцагчийн сургалтын цагийн ачаалал, хичээл хоорондын уялдаа холбоог гаргаж өгсөн.
- Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлүүлсэн

Анхаарах асуудал:

- Хичээлүүдийн хоорондын уялдаа холбоо, өмнөх залгамжийг илүү дэлгэрэнгүй тайланд тусгах шаардлагатай.
- Төгсөгч болон оюутны сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хөтөлбөрт хэрхэн тусгасан оруулах, нотлох баримтаар баталгаажуулдаг байх

Зөвлөмж:

- Сонгон суралцах хичээлийн тоог нэмэгдүүлэх
- Хөтөлбөрийн агуулгыг шинжлэх ухаан, технологийн дэвшилтэй уялдуулан өөрчлөх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- “Менежмент” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- БСШУЯ-ны сайдын тушаал 2011, 2014
- ХААИС-ийн захирлын 2014, 2015, 2016 болон 2017 оны тушаал
- Батлагдсан сургалтын төлөвлөгөө 2011, 2015, 2017
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- Тэнхимийн хурлын тэмдэглэл 2015-2020
- Хөтөлбөрийн хичээлийн стандарт төлөвлөгөө
- ХААИС-ийн оюутны гарын авлага
- ХААИС-ийн багшийн гарын авлага
- Оюутны болон төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгаа

Онцлог зүйл/Туршлага:

- Чадамжид суурилсан суралцагчийн идэвхтэй үйл ажиллагааг голлосон, оюутан төвтэй сургалтын арга зүйг ашигладаг.
- Багш бүрээр оюутны сэтгэл ханамжийн үнэлгээг авдаг болсон нь сургалтын үр дүнг сайжруулахад түлхэц болсон.

Анхаарах асуудал:

- Сургалтын арга зүйг хөтөлбөрийн зорилготой нийцүүлэх
- Идэвхтэй сургалтын аргуудыг дурдсан боловч ямар аргыг хэрэглэдэг нь тодорхой биш байна

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээл тус бүрийн суралцахуйн үр дүн, сургалтын арга зүйн задаргааг оруулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- “Менежмент” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- БСШУЯ-ны сайдын тушаал 2011, 2014
- ХААИС-ийн захирлын 2014, 2015, 2016 болон 2017 оны тушаал
- Батлагдсан сургалтын төлөвлөгөө 2011, 2015, 2017
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- Тэнхимийн хурлын тэмдэглэл 2015-2020
- Хөтөлбөрийн хичээлийн стандарт төлөвлөгөө

- ХААИС-ийн оюутны гарын авлага
- ХААИС-ийн багшийн гарын авлага
- Оюутны болон төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгаа
- Сургуулийн цахим хуудас

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийн хэмжээнд мөрддөг оюутны мэдлэгийн түвшинг үнэлэх стандарт үнэлгээтэй.
- Оюутны мэдлэг чадвар, дадал, хандлагыг үнэлэх онооны бүтэц нь 2015 онд шинэчлэгдсэн бөгөөд тогтвортой ашиглагдаж байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ суралцагчдын оролцоо, бүтээлч хамтын ажиллагааг өргөжүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын явуулах лекц, семинар, лаборатори, бие даан ажиллах анги танхимийн хүрэлцээ, тоног төхөөрөмж, суралцах орчны талаархи оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, түүний тайлан, үр дүн, статистик тоо баримт;
- Сургалтын анги танхимийн тохижилт, ашиглалт, шинэчлэлт, засвар үйлчилгээний тайлан;
- Эрасмус төслийн хүрээнд цахим сургалтын төв байгуулсан болон тэнхимийн сургалтын орчны тохижилтонд хийсэн ажлууд ;

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай лекцийн заал, семинарын танхим, лаборатори нь дээд боловсролын байгууллагад тавигдах стандарт шаардлагыг хангасан.
- Цахим сургалт, хурал, семинар зохион байгуулахад зориулсан том дэлгэц бүхий танхим тохижуулан ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Сургуулийн орчны талаар оюутны сэтгэл ханамжийн судалгаа нь “3” үнэлгээтэй байгааг дээшлүүлэх, ажлын төлөвлөгөөнд тусган шат дараатай арга хэмжээ авах;

Зөвлөмж:

- Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ суралцагчийн суралцах орчин бүрдүүлэх, шинээр баригдах номын санд тэргэнцэртэй хүн нэвтрэх налуу зам, ариун цэврийн өрөөг бий болгох;
- Оюутны бие даан ажиллах анги танхимийн хүрэлцээг нэмэгдүүлэх;

Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт явуулахад шаардлагатай хичээл практикийн хэрэгсэл хэвлэмэл үзүүлэн тараах материалын статистик тоо баримт;
- Сургалтын интернет орчин, програм хангамжийн жагсаалт, сургалтын хэрэглэгдэхүүний сайжруулалтын тоо баримт, тайлангууд;
- Цахим сургалтын хэрэглэгдэхүүн, түүний боловсруулалт, ашиглалт, цахим систем /Google G Suite платформ/ оруулсан байдал;

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтанд ашиглах хэрэглэгдэхүүний хүртээмжийг тасралтгүй нэмэгдүүлж ирсэн

Анхаарах асуудал:

- Багш нарын ном тууривах хэвлүүлэх тал дээр дэмжлэг үзүүлэх;
- Шинээр нэвтрүүлж байгаа удирдлагын мэдээллийн системийн ашиглалтыг жигдрүүлэх, шаардлагатай мэдээллийг оруулах;

Зөвлөмж:

- Сургалтанд ашиглаж буй зарим програмуудыг лицензжүүлэх;
- Хуулбарлалтыг илрүүлэх програм хангамжийг сургалт, судалгаанд нэвтрүүлэх;
- Цахим сургалтын төвийн ашиглалтыг дээшлүүлэх, багш нарын видео хичээл бэлтгэх ажлыг эрчимжүүлэх;
- Багш нарын сургалтын багц материалын стандартыг нэг болгох, бүрдүүлэлтэнд тавих хяналтыг сайжруулах;

Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрт ашиглах сурах бичгийн судалгаа;
- Сурах бичгийн фондын баяжилт, худалдан авалт, шинэчлэлтийн тайлан мэдээ, тоо баримт;
- Цахим ном сурах бичиг, түүний ашиглалт, номын сангийн тайлан мэдээ;

Онцлог зүйл/Туршлага:

- Шинээр 4 давхар бүхий номын сан ашиглалтанд орсноор оюутанд үзүүлэх үйлчилгээ, оролцогч талуудын сэтгэл ханамж дээшлэх сайн талтай

Анхаарах асуудал:

- Багш нарын ном сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл тууривалтыг дэмжих, түүний үнэлгээг сайжруулах, багш нарт ээлтэй болох, эрдэм шинжилгээний ажил хийх хөшүүрэг бий болгох;
- Номын сангийн ажиллах хуваарийг уян хатан болгох

Зөвлөмж:

- Сүүлийн үеийн ном сурах бичиг, эрдэм шинжилгээний сэтгүүлийн захиалгыг нэмэгдүүлэх;

Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС нь зохион байгуулалтын хувьд бүтцийн болон харьяа сургалт, эрдэм шинжилгээний байгууллагатай байна.
- Сургалтын бодлого зохицуулалтын алба нь их сургуулийн сургалтын бодлого, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангадаг.
- Хөтөлбөрийн хорооны журамаар хөтөлбөрийг боловсруулах, хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд бүх шатны (хөтөлбөрийн ерөнхий хороо, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо, мэргэжлийн хөтөлбөрийн хороо) хорооны ажиллах журмыг баталсан.

- Дүрэм журмын шинэчлэлд бүх багш нарын саналыг тусгадаг. Багш нарын болон тэнхимийн жилийн ажлын төлөвлөгөөг болвсруулж мөрддөг.
- Оролцогч талуудаас ирсэн санал гомдлыг холбогдох алба хэлтсүүд шийдвэрлэдэг.
- ХААИС-ийн удирдлага мэдээллийн системийг (ISLS) 2020 оноос ашиглаж байна. Уг системд бүрэлдэхүүн 5 сургуулийн 15 мянга гаруй оюутан, 700 гаруй багш ажиллагсад, 3000 гаруй хичээлүүд, 220 мянга гаруй дүн, 30 мянга гаруй төгсөгч, 210 мянга гаруй санхүү бүртгэлийн мэдээлэл бүхий нэгдсэн сан юм.
- Удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн, мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлсэн нь дараах системүүдээс харагдаж байна.
- ХААИС-ийн цахим: <https://muls.edu.mn/>
- Сургалтын удирдлагын мэдээллийн систем: ISLS.muls.edu.mn
- Санхүүгийн программ: <https://www.unicus.mn/nar/>
- Багшийн хөгжил программ: Teacher.muls.edu.mn
- Оюутны программ: Student.muls.edu.mn

Онцлог зүйл/Туршлага:

- НББ хөтөлбөрийг мэргэжлийн хөтөлбөрийн хороо боловсруулж мэргэжлийн хөтөлбөрийн хороо, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо, ерөнхий хөтөлбөрийн хороо гэсэн дарааллаар үе шаттайгаар хэлэлцүүлдэг.
- Дотоод нөөц бололцоогоо ашиглан ISLS системийг хөгжүүлж байгаа

Зөвлөмж:

Хөтөлбөр шинээр батлуулах, өөрчлөлт оруулах, оролцогч талуудын хүсэл, шаардлага хүлээн авах үйл явцыг сайжруулах, боловсронгуй болгох

- ХААИС, ЭЗБС-ийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан тэнхимийн стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх

Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- ЭЗБС нь 8 улсын 35 ИДС-тай хамтын ажиллагааны гэрээтэй.
- Менежментийн тэнхимийн багш нар жилд 10 аас доошгүй төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг. Эдгээр төсөл хөтөлбөрүүдийн үр дүнд :

Цахим сургалтын материал боловсруулах, зарим мэргэжлийн хичээлүүдийн иж бүрэн цахим сургалтын материал бэлтгэсэн. Цахим сургалтын бичлэгийн студиг 215 тоот өрөөнд байгуулсан. Зарим нэг судалгааны үр дүнгээр гарын авлага боловсруулж түүнийг сургалтанд ашиглаж байна.

- Багш нар урт богино хугацаагаар мэргэжил дээшлүүлдэг.

- БНХАУ ын Эрээн хотын багшийн ИС-тай 2+2 хөтөлбөр хэрэгжүүлдэг. Япон улсын Куматогийн ИС-д нэг оюутан жилийн хугацаатай оюутан солилцоонд хамрагдсан.
- Нийгэмд үзүүлэх үйлчилгээ тогтмолжсон. Тухайлбал: Менежментийн улсын олимдиад, “Байгалийн нөөц ба хөдөө аж ахуйн эдийн засаг” ОУЭШХ, “Ирээдүйн СЕО”, хөтөлбөр сурталчлах өдөрлөг гэх мэт.
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа тогтмолжсон. Менежментийн тэнхимийн төгсөгчдийн холбоо байгуулагдан ажиллаж байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Тус тэнхимийн багш нар 2015-2020 онуудад 32 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн
- Менежментийн улсын олимдиадыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдөд зориулсан сургалт, семинар зохион байгуулах, тасралтгүй хөгжүүлэх тал дээр хангалтгүй ажиллаж байна.
- Удирдлагын мэдээллийн систем тогтворгүй, богино хугацаанд солигдож байна.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг эрчимжүүлж сайжруулах, сурталчилах
- Төгсөгчдөд давтан сургалт зохион байгуулах зэрэг тасралтгүй боловсролын системийг хөгжүүлэх

Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн орлого нь ХААИС-ийн нэгдсэн төсөвт төвлөрч жил бүр ХААИС-ийн удирдах зөвлөлийн хурлаар төсөв батлагдаж, батлагдсан төсвийн хүрээнд ЭЗБС санхүүждэг.
- Кредит цагийн төлбөр тухайн хичээлийн сургалтын төлөвлөгөөний аль хэсэгт хамаарч байгаагаас шалтгаалан ялгаатай байдаг. Дунджаар нэг оюутан жилд 32-36 кц хичээл судалбал 2240,0-2520,0 мянган төгрөгийн төлбөр төлж байна.
- ХААИС-ийн санхүүгийн журмын дагуу хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж, бүрэлдэхүүн сургууль жил бүрийн төсөвтөө хөтөлбөрийн шинэчлэлт өөрчлөлт болон бусад ЭШ-ний үйл ажиллагаанд зориулан жил бүр тодорхой хөрөнгө төсөвлөн зарцуулан ажилладаг.
- Менежментийн тэнхим нь хувийн хэвшил болон төрөөс шууд дэмжлэг, хандив тусламж авдаггүй.
- Орлогын эх үүсвэрийн 87-97 хувь нь баклаврын сургалтын төлбөр байдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн, шинэчлэлт өөрчлөлтөд зориулж жил бүрийн төсөвт хөрөнгө оруулалт, эрдэм шинжилгээ судалгааны

ажил, багш нарын мэргэжил дээшлүүлэх зардлуудыг төсөвлөж, зарцуулдаг.

Анхаарах асуудал:

- Тэнхим болон хөтөлбөр бие даасан санхүүгийн эрх мэдэлгүй
- Тэнхим сургалтын төлбөрийн орлогоос бусад төрлийн орлогын эх үүсвэргүй байна.

Зөвлөмж:

- Төсөл, хөтөлбөр, сургалт, судалгааны ажил зэрэг олон эх үүсвэрээс санхүүжих боломжийг судлан төлөвлөж, хэрэгжүүлэх.
- Хөтөлбөрийн өртөг зардлын тооцооллыг боловсронгуй болгох.

Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг ХНХЯ-ны дэргэдэх судалгааны институтээс гаргадаг “Хөдөлмөрийн зах зээлийн барометр”-ийн судалгааны үндэслэн хийдэг.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин 74 хувь.
- Хөтөлбөрийн судалгааг ХААИС, ЭЗБС-ийн веб сайт, фэйсбүүк хуудас, мэдээллийн самбар зэргээр сурталчилдаг.
- Боловсролын үзэсгэлэн яармаг, өдөрлөгүүдэд тогтмол оролцдог.
- ХААИС-ийн захирлын тушаалаар “Маркетингийн идэвхжүүлэлт” хөтөлбөрийг 2015-2019 онуудад хэрэгжүүлсэн. Энэ хөтөлбөрийн хүрээнд “Мэргэжил миний ирээдүй”, “Элсэлтийн нээлттэй мэдээлэл”, “ХААИС-ийн элч оюутан”.
- 2019-2020 оноос” ХААИС-ийн элсэлтийн маркетингийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлсэн.

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийн элч оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлж хөдөө орон нутгаас оюутан элсүүлэх ажил зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Элсэгчдийн тоо буурч байна
- Менежмент хөтөлбөрийн сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулах

Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Тус тэнхим нь сургуулийн вэб сайт, дотоод мэдээллийн сүлжээ, ТВ, радио, сэтгүүл, цахим сайт зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тэнхимийн мэдээ, мэдээлэл, ололт амжилт бусад үйл ажиллагааг сурталчилдаг.
- Тэнхим тусдаа вэбсайт хөтөлдөггүй, ЭЗБС-ийн вэбсайтаар дамжуулан хөтөлбөрийн танилцуулга, мэдээллийг олон нийтэд хүргэдэг.
- Дотооддоо мэдээлэл солилцох зорилго бүхий олон нийтэд чиглсэн фэйсбүүк пейж хуудас, группуудээр дамжуулан мэдээллийг хүргэдэг.
- Тэнхимийн танилцуулга буланг ажиллуулдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын үйл ажиллагаанд зориулан сурах бичиг, монограф, гарын авлага, боловсруулан олны хүртээл болгодог.

Анхаарах асуудал:

- Тэнхим, хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар сүүлийн үеийн шинэ мэдээллийг тухай бүр хүргэхэд анхаарах хэрэгтэй.

Зөвлөмж:

- Тэнхим, хөтөлбөрийн шинэ мэдээллийг тухай бүрд олон сувгаар түгээж байх
- Удирдлагын мэдээллийг цаг тухайд нь түргэн шуурхай хүргэх

Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн элсэлтийн журам /сүүлийн 5 жил батлагдсан/;
- Элсэгчдийн шалгалтын босго оноо, элсэгчдийн дундаж онооны судалгаа;
- Элсэгч болон хүсэлт гаргагчдын харьцуулсан судалгаа;
- Элсэгчдэд зориулсан гарын авлага, мэдээллийг олон сувгаар нээлттэй хүргэдэг,

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэгч болон оюутнуудад зориулсан гарын авлагыг жил бүр шинэчлэн сайжруулан хэвлүүлэн олны хүртээл болгодог;
- Элсэлтийн өөрийн програмаар дамжуулан элсэлтийн зохион байгуулдаг;

Анхаарах асуудал:

- Сургуулийн захиргаанаас баталсан тухайн хөтөлбөрөөр оюутан элсүүлэх төлөвлөлт, түүний биелэлтийг дүгнэн, шинжилгээ тогтмол хийх

Зөвлөмж:

- Элсэлтийн маркетингийн ажлыг сайжруулах, хөтөлбөрөөр элсэгчдийн тоог нэмэгдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны хөгжил хөтөлбөр, оюутны гарын авлага
- Тэнхимийн болон зөвлөх багш нарын ажлын төлөвлөгөө, тайлан
- Зөвлөх багш болон оюутнаас авсан сэтгэл ханамжийн судалгаа
- Оюутны зөвлөлийн төлөвлөгөө, тайлан

Онцлог зүйл/Туршлага:

- Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг албан тушаалтнуудад үнэлгээ хийж, үйлчилгээг сайжруулан ажилладаг
- ОЭШ-ний ажлыг дэмжин эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулж ирсэн,
- Оюутны клуб, дугуйланд хамрагдалтын судалгааг тогтмол хийдэг

Анхаарах асуудал:

